

## Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлын тэмдэглэл

2015.04.29

Улаанбаатар хот.

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал, хурал хийхээр товлосон зарын дагуу 2015.04.29 ний өдрийн 14 цагт бүртгэл эхэлж, 14 цаг 30 минутад Компанийн танхимд болов.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн хурлын ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын комиссын 2015.04.29 ний өдрийн "Хурал хүчин төгөлдөрт тооцох" № 01 тоот тогтоолыг уншиж танилцуулав. / уг тогтоолыг хурлын материалын .....-р хуудсанд хавсаргав /

Тооллогын комиссын Ц.Бодьгэрэл : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд 1.023.703 ширхэг хувьцаа эзэмшсэн 3898 хувьцаа эзэмшигчдээс саналын эрх бүхий 3898 ширхэг хувьцаа эзэмшсэн, 173 хувьцаа эзэмшигч ирсэн байна. Энэ нь нийт хувьцааны 80,9 %ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн "Хурал хүчин төгөлдөрт тооцсугай" гэв.

Үүний дараа Хурлын дарга, тэргүүлэгчид, нарийн бичгийн даргаар хэн хэнийг сонгох саналтай байгаа талаар асуухад:

Хувьцаа эзэмшигч Одонгэрэл : Хурлын даргаар хувьцаа эзэмшигч Л.Янжин, тэргүүлэгчдээр хувьцаа эзэмшигч Оюунцэцэг, хувьцаа эзэмшигч Гантөмөр нарыг, нарийн бичгийн даргаар хувьцаа эзэмшигч Х.Сарангэрэлийг сонгох саналтай байна гэв. Хувьцаа эзэмшигчид уг саналыг 100% санал нэгтэй баталж, хурлын дарга, тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга нарыг ажилдаа орохыг урив.

Хурлын дарга Л.Янжин хурлыг нээж, хуралд ирсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, компанийн удирдлагуудыг танилцуулж, "Хурлын дэгээ батлах уу" гэхэд хувьцаа эзэмшигчид санал нэгтэй батлав. Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан,
2. Компанийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
3. Компанийн Аудитын Хорооны тайлан
4. Компанийн 2015 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
6. 2015 оны ТУЗ-ын төсвийг батлах
7. Ногдол ашгийг 120 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалаал ёсоор:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайланг Компанийн гүйцэтгэх захирал М.Базар-Ууган
2. Компанийн 2014 оны санхүүгийн тайланг ерөнхий нябо Б.Бурмаа
3. Компанийн Аудитын Хорооны тайланг дотоод аудитор С.Дүгэр нар тайлагнав.

Илтгэлүүдийн дараа Нэр Дэвшүүлэх Хорооны гишүүн Н.Мөнхцэцэг :Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр нэр дэвшигчдийн товч намтарыг уншиж



танилцуулж Компанийн хуульд заасан Төлөөлөн Удирх Зөвлөлийн хараат бус гишүүн байх шаардлагыг хангасан талаар тайлбар хийв.

Хурлын дарга Л.Янжин : Одоо санал, шүүмжлэлдээ оръё. Хэнд ямар санал, шүүмжлэл байна вэ?

Хувьцаа эзэмшигч Өсөхбөяр : Юуны өмнө энэ компанийн хамт олонд талархал илэрхийлье. Илтгэлүүд маш сайн болсон байна, техник төхөөрөмжүүд ашиглаж илтгэлээ тавьсан нь их сонирхолтой боллоо. Их зүйл хийсэн байна. Би үйлдвэрээ өнөөдөр үзлээ. Надад их сайхан сэтгэгдэл төрлөө, үнэхээр л үзүүлэх зүйлтэй, нүүр брдам байгааг хараад баярлаж байлаа

Хувьцаа эзэмшигч Баттогтох : Аудитын Хорооны илтгэлийг сонслоо, бүх үзүүлэлтүүд өссөн дүнтэй гарсан байна, санхүүгийн тайлангаа сонинд хэвлэснийг олж үзсэн. Жил бүр ашиг өсөж тэр чинээгээрээ ногдол ашиг өсдөг, цагтаа ногдол ашгаа тараадаг, ирэх жил ногдол ашгаа арай нэмэгдүүлэх боломж бололцоо байна гэж бодож байна. Миний саналыг хүлээн авна гэдэгт итгэж байна.

Хувьцаа эзэмшигч : Би үйлдвэрийг дараа завтай үедээ ирж үзэж болох уу?

Хурлын дарга Янжин: Та завтай үедээ хэзээ ч ирж үзэж болно. Манай үүд хаалга нээлттэй, ер нь гадаадын хувьцаа эзэмшигч нар хүртэл ирж үйлдвэр үздэг болсон, үзээд сэтгэл хангалуун байдаг.

Хувьцаа эзэмшигч Нанзадсаурэн: Манай үйлдвэр бусад үйлдвэрүүдийг бодвол амт чанар сайтай олон төрлийн талх, нарийн боов үйлдвэрлэдэг болжээ. Социализмын үед чихэр их хэмжээгээр үйлдвэрлэдэг байсан, үүнийгээ үргэлжлүүлэх үү?

Гүйцэтгэх захирал Базар –Ууган: үргэлжлүүлнэ, тантай санал нэг байна . энэ ондоо чихрийн үйлдвэр барьж ашиглалтанд орно.

Хувьцаа эзэмшигч Алтансүх : Би хуралдаа хоцорч ирсэн, гэхдээ намайг орууллаа, зарим компани ирцээ тасалсан гээд оруулдаггүй, хурал зохион байгуулалт сайтай болж байна, их зардал гаргасан байна, компанийн гадна дотно тохижилт, офисс, үйлдвэрүүд их сайхан байна, хувьцаа эзэмшигч бидэнд их хүндэтгэлтэй ханддаг, үйлдвэрээ үзүүлдэг, зоог барьдаг, мөн бүтээгдэхүүний дээж өгдөгт баярладаг, тиймээс хувьцаа эзэмшигч бид нар хуралдаа ирэх сонирхол их байдаг, 2014 оны ногдол ашгийг 07-р сарын 01 ээс тараана гэж ТУЗ ийн тогтоолд бичсэн байна, энэ хугацаандаа өгч чадах уу?

Ерөнхий нябо Б.Бурмаа: Өгч чадна, хугацаандаа тараах боломж бололцоо байгаа. Хугацаандаа өгч чадна.

Хувьцаа эзэмшигч Мөнхзул: Тайланд олон улсын стандартыг нэвтрүүлэхээр баг байгуулан ажиллаж байна гэж гэж ярилаа, энэ талаараа тайлбарлаач. Олон улсын стандартыг нэвтрүүлэхийн тулд өмнө нь маш их бэлтгэл ажил хийдэг, бид үүнийгээ бэлдэж байна, бичиг цаасны ажлаас гадна бүх ажилчиддаа сургалтыг шатлалтайгаар зааж байна. Үүнд оролцохгүй хүн байхгүй, үүнийг нэвтрүүлвэл гадаад зах зээлд компанийн нэр өсөх боломжтой болно.

Тулгат Чандман Баян БДК : Би компаниа төлөөлж хуралд оролцож байна. Манай компаниар үйлчлүүлдэг хувьцаа эзэмшигч нар хурлын материалтай танилцдаг, сүүлийн үед гадаад хувьцаа эзэмшигч нар хурлын материалтай онлайнаар танилцахыг хүсдэг боллоо. Хурлын материал болон саналын хуудсыг англи хэлээр хэвлэж болох уу?



14

Гүйцэтгэх захирал М.Базар –Ууган :Тиймээ, манай компанийн хувьцаа эзэмшигч Турк хүн , хурлын материалтай танилцахаар мэйлээр авсан,таны саналыг хүлээн авлаа.

Хурлын дарга Л.Янжин:Та бүхний үнэтэй саналыг бид сонслоо, хурлын тэмдэглэлд тусгагдаж байгаа, хойшид бид ажилдаа тусгаж ажиллах болно, та бүгдэд баярлалаа. Санал, шүүмжлэлээ таслах уу гэхэд бүгд зөвшөөрлөө.

Баярлалаа, та бүхэнд өөр санал, хүсэлт байхгүй бол тооллогын комисс санал хураалтын дүн гартал түр завсарлая.

Үүний дараа тооллогын комиссын дарга Ц.Бодьгэрэл “ Саналын хуудсыг тоолж, дүнг хуралд танилцуулах тухай ” тогтоолыг уншиж танилцуулав. / уг тогтоолыг хурлын материалын -р хуудсанд хавсаргав./

Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хуралд 173 ширхэг саналын хуудас буюу 828515 ширхэг хувьцааны санал иржээ. Хуралд ирүүлсэн саналын хуудсыг нэг бүрчлэн шалгаж үзэхэд ширхэг саналын хуудсыг буюу 828515 ширхэг хувьцааны санал хүчинтэйд тооцов.

. Хурлаар хэлэлцсэн асуудал тус бүр дээр тоолж үзвэл:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайланг батлахыг зөвшөөрсөн 828.515 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 %, татгалзсан ...~~...~~ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~%..., түдгэлзсэн ...~~...~~ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~%.. байна.

2. Компанийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт болон хараат бус аудитын дүгнэлтийг батлахыг зөвшөөрсөн 828505 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9 %, татгалзсан 10 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,001 %, түдгэлзсэн ~~...~~ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~хувь байна..

3. Компанийн Аудитын Хорооны тайланг батлахыг зөвшөөрсөн 828504 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9 %,татгалзсан 11 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,001%, түдгэлзсэн...~~...~~ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~% байна.

4. Компанийн 2015 оны зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 828504 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9%, татгалзсан 11 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,01% ,түдгэлзсэн ...~~...~~ширхэг хувьцаа буюу нийт саналын...~~...~~% байна.

5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

\* Х. Баттуулыг сонгохыг зөвшөөрсөн 828515 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 %, татгалзсан ..... ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ %, түдгэлзсэн ....~~...~~ширхэг хувьцаа буюу нийт саналын ..... % байна.

\*Н.Мөнхцэцэгийг сонгохыг зөвшөөрсөн 828504 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9 %, татгалзсан 11 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,01%, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~% байна.

\*Д.Цэнддоржийг сонгохыг зөвшөөрсөн 828504 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9 %, татгалзсан 11 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.01% , түдгэлзсэн.....~~...~~ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~% байна.



15  
\*Б.Оюунмаг сонгохыг зөвшөөрсөн 828504 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9 %, татгалзсан 11 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.01 %, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ % байна.

\*Х.Цэндбаярыг сонгохыг зөвшөөрсөн 828504 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9 %, татгалзсан 11 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.01 %, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ % байна.

\*Францис Ли Бун Кимийг сонгохыг зөвшөөрсөн 828291 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9%, татгалзсан 224 ширхэг хувьцаа нийт саналын 0.01 %, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа нийт саналын ~~...~~ % байна.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр :

\*Х.Гиймаг сонгохыг зөвшөөрсөн 828512 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9%, татгалзсан 3 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,01 %, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ % байна.

\*Л.Дамдинсүрэнг сонгохыг зөвшөөрсөн 828512 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99.9 %, татгалзсан 3 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0.01%, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ % байна.

\*Д.Сэр-Одыг сонгохыг зөвшөөрсөн 828512 ширхэг хувьцаа буюу нийт саналын 99,9 %, татгалзсан 3 ширхэг хувьцаа буюу нийт саналын 0,01%, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ % байна.

5. Компанийн 2015 оны ТУЗ- ийн төсвийг 12.460.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн 828515 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 %, татгалзсан ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ %, түдгэлзсэн ~~...~~ ширхэг буюу нийт саналын ~~...~~ % байна.

6. Ногдол ашиг хуваариалахыг зөвшөөрсөн 828515 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 %, татгалзсан ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ %, түдгэлзсэн ~~...~~ ширхэг хувьцаа буюу нийт саналын ~~...~~ % байна.

гэж танилцууллаа.

Үүний дараа тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ –өөс өгсөн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.

2. Компанийн Аудитын Хорооны тайланг баталсугай.

3. Компанийн 2015 оны зорилт, төлөвлөгөөг баталсугай.

4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

\*Х. Баттуулыг 100% ийн саналаар

\*Н.Мөнхцэцэгийг 99.9% ийн саналаар

\*Д.Цэнддоржийг 99.9 % ийн саналаар

\*Б.Оюунмааг 99.9% ийн саналаар

\*Х.Цэндбаярыг 99.9 % ийн саналаар

\*Францис Ли Бун Кимийг 99.9% ийн саналаар тус тус сонгосугай.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

\*Х.Гиймааг 99.9 % ийн саналаар

\*Л.Дамдинсүрэнг 99.9 %-ийн саналаар

\*Д.Сэр-Одыг 99.9 % ийн саналаартус тус сонгосугай.

5. 2015 оны ТУЗ-ийн төсвийг 12.460.000 төгрөгөөр баталсугай.

6. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 120₮-өөр тогтоосугай  
гэсэн тогтоолыг гаргаж танилцуулахад хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтэй батлав.

Үүгээр хурлын ажиллагаа 16 цаг 10 минутад өндөрлөв.

Хурлын дарга:

Тэмдэглэсэн:



Л.Янжин

Х.Сарангэрэл